



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

**АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ САНААГИЙН  
АЛТАНЦЭЦЭГ ТАНАА**

2020.09.03 № 007 2020/06-НА-53  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Санаагийн Алтанцэцэгийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч С.Алтанцэцэг нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050” холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

## Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч С.Алтанцэцэгийн Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч С.Алтанцэцэгийн мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Алтанбулаг сумын Сонгуулийн хороонд


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН 2020 ОНЫ ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
САНААГИЙН АЛТАНЦЭЦЭГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



Уриа: ТА САНАЛАА ХЭЛ, ТАНЫ ГҮҮР БОЛЖ, ТӨРӨЛХ НУТГАА ХӨГЖҮҮЛБЭ.

**НЭГ: ИРГЭДИЙН ОРОЛЦОО:**

- 1.1. Сумын “Иргэний танхим”-ийн үйл ажиллагааг сайжруулж, иргэдийн санал хүсэлтийг хуулийн дагуу түргэн, шуурхай шийдвэрлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 1.2. “Орон нутгийн хөгжлийн сан”-г журмын дагуу иргэд, олон нийтийн оролцоог дэмжиж ажиллана.
- 1.3. Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлж, иргэдийн оролцооны зохистой хэлбэрүүдийг дэмжинэ.
- 1.4. Нутгийн зөвлөл болон орон нутгийн хөгжлийн төлөөх ТББ зэрэг олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 1.5. Сумын халамж үйлчилгээнд /хүнсний талонд/ хамрагдсан айл өрхүүдийн ханган нийлүүлэгчийн үнийн саналд хяналт тавьж, тэднийг чанартай хүнсээр хангаж байх асуудлыг сумын халамж үйлчилгээний байгууллагатай хамтарч хэрэгжүүлнэ.

**ХОЁР: АЮУЛГҮЙ ТАЙВАН АМГАЛАН НИЙГЭМ:**

- 2.1 Сум доторх төв зам дагуу болон хорооллын дундах замын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.2. “Хашаандаа сайхан амьдаръя” аяныг үргэлжлүүлэн иргэдэд өөрсдийнх нь нөөц бололцоо, санал санаачлагд тулгуурлан явуулж, иргэдийн идэвхийг дээшлүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 2.3. Сумын цагдаагийн тасаг болон холбогдох байгууллагуудтай хамтран орон нутгийн шаардлагатай газруудад хурд сааруулагч хийх ажлыг эхлүүлнэ.
- 2.4. Сумын эзэнтэй нохдыг бүртгэлжүүлж, бүртгэлгүй нохдыг устгах ажлыг багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулна.
- 2.5 Бар, цэнгээний газар болон РС тоглоомын газруудад тавих хяналтыг сайжруулж, насанд хүрээгүй хүүхдүүдийг оройн 22 цагаас хойш эцэг эхийн хараа хяналтгүй, гадуур тэнүүлэхгүй байх асуудал дээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 2.6 “Архигүй сум” хөтөлбөр боловсруулж амжилттай ажиллаж байгаа аймаг, сумдаас туршлага судлан өөрийн сумандаа нэвтрүүлэх боломж, нөхцөлийг судалж, холбогдох байгууллагуудад уламжилна.
- 2.7 “Хөршийн холбоо”-г сайжруулж, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.8 Ард, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гудамж, замыг камержуулах ажлыг дэмжин ажиллана.
- 2.9 Сургууль орчмын ногоон байгууламжийг хүүхдийн амралт тав тухад тохируулан засаж тохижуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлүүлнэ.



### **ГУРАВ: ЭРҮҮЛ ЭНХ, ЗӨВ АМЬДРАЛ**

- 3.1 Хүн амд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, нийтийн биеийн тамирыг дэмжсэн арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран насны ангиллаар зохион байгуулна.
- 3.2 Спортын төрлүүд тэгш хөгжих нөхцөлийг хангах зорилгоор сумын авьяаслаг иргэдийг түшсэн сургалт, секц хичээллүүлэх боломжийг судлан хэрэгжүүлнэ.
- 3.3 Сумын эрүүл мэндийн төвтэй хамтарч иргэдээ жилд нэг удаа зохион байгуулалттайгаар эрүүл мэндийн шинжилгээнд сумандаа хамруулах ажлыг эхлүүлнэ.
- 3.4 Сумын ахмадын хорооны үйл ажиллагааг өргөжүүлж, тэднийг урамшуулж, нийт ахмадуудынхаа урлаг, спортыг дэмжсэн олон талт үйл ажиллагаа явуулахад нь дэмжин ажиллана.
- 3.5 Сумын хог хаягдлын асуудлыг цэгцлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.6 Сумын төвлөрсөн халаалтад хяналт тавих, 5 давхрын уурын зуухыг ашиглалтад оруулж “Залуучуудын хороолол”-ын айлуудыг дулаанаар хангах ажлыг холбогдох байгууллагын оролцоотойгоор шийдвэрлэнэ.

### **ДӨРӨВ: ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ АМЬДРАЛЫН БАТАЛГАА**

- 4.1 Хүүхэд залуучуудыг хөгжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчин бүрдүүлэх тал дээр сум орон нутгийн удирдлагууд, залуучуудын байгууллагуудтай хамтран ажиллана.
- 4.2 Сум орон нутгийнхаа уугуул залуучадварлаг боловсон хүчнийг өөрийн орон нутагтаа ирж ажиллаж амьдрахад нь дэмжлэг үзүүлэхэд анхаарна.
- 4.3 Сургуулийн дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулахад анхаарч, тэдний эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллана.

### **ТАВ: ҮЙЛДВЭРЖИЛТ ЭДИЙН ЗАСГИЙН ТААТАЙ ОРЧИН**


- 5.1 Сумандаа чөлөөтэй цахим орчин бүрдүүлэх нөхцөлийг судлан холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 5.2 Сумын онцлогийг харгалзан гялгар уут, хуванцрын түүхий эд жижиглэн савлах үйлдвэрийг байгуулах ажлыг дэмжин ажиллана.

### **ЗУРГАА : ДЭД БҮТЭЦ ХӨГЖЛИЙН ҮҮД**

- 6.1 Иж бүрэн тоног хэрэгсэл бүхий спортын цогцолбор, соёл амралтын хүрээлэнг нутгийн иргэд, олон нийтийн санал санаачилгад тулгуурлан “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр байгуулж болохыг судална.
- 6.2 Түүхэн болон байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглүүлэн байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх түүнээсээ нутгийн иргэд орлогч олох боломжийг судална.

### **ДОЛОО: БАЙГАЛЬ ОРЧИН ХӨДӨӨ АЖ АХУЙ**

- 7.1 Сумынхаа иргэдийн галын түлээ болон хэрэглээний модны хэрэгцээг хангах зорилгоор тус сумын ойн сангийн нөхөрлөлүүдтэй зөвшилцөн шийдэлд хүрч болох замыг хайна.
- 7.2 “Нэг сум-нэг үйлдвэрлэл” хөтөлбөрийг үргэлжлүүлэн, бодлогын хүрээнд суманд нэн тэргүүнд шаардлагатай байгаа ЖДҮ-ийг хөгжүүлэх ажлыг судлан холбогдох байгууллагуудтай хамтарч шийдвэрлүүлнэ.



7.3 Сумын газар тариалан эрхлэгчид болон мал бүхий иргэдийн эрх ашгийг хамгаалах тал дээр зохих шатны байгууллагуудтай зөвшилцөн шийдвэрлүүлнэ.



НЭР ДЭВШИГЧ:

С.АЛТАНЦЭЦЭГ

2020 оны 07-р сарын 24